

Дурсамж ба дурдатгал

Геологийн асуудлууд хэмээх энэхүү эрдэм шинжилгээний бичигт ахиад геологийн ололт амжилт, тэдний амьдралд тохиолдсон адал явдлын тухай дурсамж, дурдатгалыг боломжтой бол зургийн хамт нийтлүүлж байхаар булан нээж байна. үүний анхных нь ахмад багш, хүндэт профессор Баянтөрийн, проф. С.Дашдаваагийн тухай дурссан, магистр Одгэрэлийн багш А.Перлээтэй хийсэн ярилцлага болон ахмад геологч Л.Шархүүгийн өөрийн тухай дурдатгалыг нийтлүүлж байна. Жилд 2 удаа хэвлэгддэг эрдэм шинжилгээний бичгийн энэхүү буланд идэвхитэй оролцож байхыг уриалж байна.

ГЕОЛОГИ-ГАЗАРЗҮЙ БОЛ ХҮЙН ХОЛБООТОЙ АХАН ДҮҮС ШИНЖЛЭХ УХААН МӨН

Ахмад багшийн дурсамж

Эртний грекийн эрдэмтэн Эратосфен (манай эрний өмнөх 276-194 он)-ийг Газарзүйн ухааны "эцэг" хэмээн нэрлэдэг бөгөөд тэрээр өөрөө Газарзүй бол бүх шинжлэх ухааны "ээж" нь гэж бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл Газарзүйгээс орчин үеийн олон шинжлэх ухаан, түүний дотор "Геологи" бие дааж хөгжсөн түүхтэй.



Монгол улс, МУИС-д Геологийн мэргэжлийн анги, салбарыг байгуулахдаа Газарзүйн салбараа түшиглэж байсан нь тохиолдлын хэрэг бус. МУИС-д Газарзүйн салбар ангийг нээж хичээллэснээс хойш 4жилийн дараа буюу 1960 онд БНМАУ-ын СнЗ ба МАХН-ын Төв Хорооны (тэр үеийн нэрээр) тогтоолоор

МУИС-д Геологийн салбарыг байгуулахдаа Газарзүйн III ангиас нэр бүхий 13 оюутныг шилж сонгон авч байсан ба геологийн мэргэжлийн багш Ж.Дүгэрсүрэн МУИС-ийн Байгалийн Ухааны Факультет (БУФ)-ийн харъяа Газарзүйн тэнхимд харъяалагдаж байсан байх юм.

Дараань МУИС-ийн харъяа Политехникийн дээд сургууль (ПДС) байгуулагдахад Газарзүй, Геологийн салбарыг 1967 онд БУФ-иас өрх тусгаарлан Геологи-Газарзүйн Факультет (ГГФ) хэмээн нэрлэж одоогийн ШУТИС-ийн I байр (хуучин эдийн засгийн дээд сургууль)-ны 2-р давхарын хойд хэсэгт байршуулсан юм. Тэр үед газарзүйн тэнхимийн эрхлэгчээр З.Мөнхөө, Геологийн тэнхимийн эрхлэгчээр С.Дашдаваа, Деканаар одоогийн гавъяат багш Ж.Лхамсүрэн, Деканы туслахаар Н.Баартуу нар ажиллаж байлаа.

Манай Факультет авсаархан, эмх журам, ажил төрөл сайтай, МУИС-ийн тэргүүний факультетийн нэг байсан. Газарзүйн салбар нь охидууд олонтой, харин Геологи нь хөвгүүд олонтой байсан учир Газарзүйгээсээ "бэр" буулгах нь олонтой байсныг санаж байна.

1982 онд ПДС, МУИС-иас бие даан тусгаар тогтноход Газарзүйн салбар нь МУИС-ийн БУФ-д харъяалагдах болж МУИС "Геологич" мэргэжилтэн бэлддэг анги салбаргүй болсон.

1990-ээд оноос МУИС-ийн ректороор химич мэргэжилтэй Д.Дорж томилогдон ажиллах болсноор Геологийн мэргэжлийн анги нээх тухай асуудал тавигдсан. Тэр үед МУИС-ийн тэнхимийн эрхлэгч нарын зөвлөлгөөн дээр (чухам хэдэн оны хэдэн сарын хэднийг санахгүй байна) ректор Д.Дорж МУИС-ийн бүтцийн хэтийн төлөвийн тухай яриандаа " Гадаад орнуудын их сургуулиуд олон мэргэжилтнийг бэлддэг юм байна. Одоо манай МУИС-д Геологийн мэргэжилтнийг бэлтгэх шаардлагатай

боллоо. Байгалийн суурь ухааны нэг нь Газар-дэлхийн судлал, түүний дотор геологийн ухаан байдаг. Сонгодог их сургууль байхын тулд геологийн мэргэжилтэн бэлтгэдэг, судалгааны ажил явуудаг байх ёстой." Гэх мэтээр ярьж санал дэвшүүлж байсныг бид дэмжиж байснаа би тод санаж байна.

Удалгүй 1991 онд МУИС-ийн ректорын тушаал гарч мөн л газарзүйн салбарын 2-р курсээс 6 оюутныг сонгон авч Геологийн салбар байгуулагдаж сургалтын ажлаа эхэлсэн түүхтэй. 1998 онд БУФ задарч хэд хэдэн факультет болоход Газарзүй, Геологи хамтран тусдаа гарч өөрийн факультетийг нээснээс хойш өдийг хүрчээ. Ингэж л бид цаг хугацаа өнгөрөх тусам бие биеэ дэмжин түшилцсээр, цуг амьдарч ирсэн юм дээ



ПДС-иас МУИС-д Геологийн салбарыг 2 дахь удаагаа нээн хичээллэхэд санаа зоригоо шулуутган ПДС-иас МУИС-д шилжин ирж ёстой "Ханцуй шамлан" ажилласан багш нарын дотор С. Дашдаваа Я. Болд нар байсан. Эдгээрээстэнхимийн эрхлэгчээр томилогдон ажиллаж байсан Проф С. Дашдаваагийн талаар хэдэн үг хэлье: Тэрээр газарзүйн салбарт оюутнаар элсээд анхны цуваанд газарзүйгээс геологит шилжин суралцсан юм. Бид 2 Завханы төвийн 10 жилд суралцаж төгссөн хүмүүс. Бид төө зайгүй найз нөхөд байсан гэвэл худлаа. Нэг 10 жилд суралцаж байсны хувьд (би 10-р ангид, мань хүн 7-р ангид суралцаж байв.) бие биеэ мэднээ. Мэндтэй, устай л явдаг байлаа. Юманд няхуур хичээнгүй хүн юмдаа л гэж дүгнэдэг байсан. Хурал, цуглаан дээр хааяа нэг үг хэлэхдээ оновчтой, цэгцтэй цөөхөн үг хэлнэ. 10 жилд байхад нь ангийнх нь хүүхдүүд "хандгай" гэж дууддаг байсан нь үнэхээр өөрт нь тохирсон нэр хоч байжээ.

ПДС-д сургалт эрхэлсэн дэд захирлаар олон жил ажиллахдаа их ч хөдөлмөрлөж тэр нүсэр сургуулийг сургалтын хувьд хөл дээр нь зогсооход их үүрэг гүйцэтгэсэн хүн байх гэж хэлэхэд олон хүн дургүйцэхгүй байх. Сайн хүнийг амьдад нь эс боловч бурхан болсон хойно нь дурсая, магтая. Даанч шүлэг бичиж, гоё сайхнаар магтаж

чадахгүй юмдаа. Шибирь ойн хандгай буга шиг тэр сайхан хүн биднийгээ орхин бурхан тэнгэртээ хальсан боловч түүний гарын олон шавь нар МУИС-ийн ГГС-ийн (2010 оны 9-р сарын 01-нээс сургууль гэж нэрлэх болсон) Геологийн салбартаа багшилж, Монгол орондоо амин чухал хэрэгцээтэй “Геологич” хэмээх мэргэжилтэн бэлтгэн төрүүлсээр байгаад ахмад багшийн хувьд би их баяртай явдаг.

Монгол улсад үндэсний геологийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын бүх геологичдод болон МУИС-ийн ГГС-ийн Геологийн салбарын бүх багш, ажилчдад халуун баяр хүргэж, ажлын их амжилт хүсэн ерөөе!!!

МУИС-ийн хүндэт профессор
М.Баянтөр